



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 17 өдөр

Дугаар А/25

Бат-Өлзий сум

Шууд худалдан авах тухай


Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, Засгийн газрын 2021 оны “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 124 дүгээр тогтоол, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “2023 оны төсөв батлах тухай” 2022 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 11/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бат-Өлзий сумын Сум дундын Ойн ангид ойн хөнөөлт шавьжаас урьдчилан сэргийлэх, хамгаалах үүргийн шүршигч багаж, хэрэгслийг нийлүүлэх ажлыг “Царс мод” хязгаарлагдмал хариуцлагатай компаниар шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлсүгэй.

2. “Царс мод” хязгаарлагдмал хариуцлагатай компанитай гэрээ байгуулж, хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

3. Ойн хөнөөлт шавьжаас урьдчилан сэргийлэх, хамгаалах үүргийн шүршигч багаж, хэрэгслийг худалдан авахад шаардагдах 7,500,000 (долоон сая таван зуун мянга) төгрөгийг гэрээний дагуу Байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардлаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН